

Дорноговь аймгийн 2010 оны онцлох 10 үйл явдал

1. Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн үүсгэн байгуулсан нүүдэлчний театрын үргэлжлэл болох “Саран хөхөө” театрын шинэ барилга ашиглалтанд орсон.



2. Орон сууцны фондыг нэмэгдүүлсэн, авто зам засч, гудамжинд нарны зайн гэрэлтүүлэг тавьсан, орчиндоо ойн зурвас байгуулсан, хог хаягдлын менежмент төсөл хэрэгжүүлсэн, Ханбаянзүрх уулын жуулчны нөхцлийг сайжруулж уулын зам тавьсан, фермерийн хэлбэрийн хэд хэдэн аж ахуй шинээр байгуулсан зэрэг амжилтаар Сайншанд хот төвийн бүсийн бүтээлч хотоор шалгарав.



3. Даланзадгад-Таван толгой-Зүүнбаян, Сайншанд - Баруун-Урт - Чойбалсан чиглэлийн төмөр зам тавих, ашигт малтмалын гаралтай түүхий эд боловсруулах "Сайншанд" аж үйлдвэрийн цогцолбор байгуулах асуудал сураг төдий байсан үед бүх суманд ярилцлага зохион байгуулж, ард иргэдийнхээ гарын үсэг бүхий саналыг УИХ-д хүргүүлсэн. Ингэснээр "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого" гэсэн баримт бичиг Монгол улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор батлагдав.



4. "Хөгжлийн төв Сайншанд" хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг Сайншанд хотод зохион байгуулж, Сайншандад хүнд аж үйлдвэрийн цогцолбор байгуулах их бүтээн байгуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг хөрөнгө оруулагчид, сонирхогчдод өгч, хамтын ажиллагааг эхлүүлэв. Мөн төрийн гурван өндөрлөг нэг жилд тус аймагт айлчилсан нь содон үйл явдал болсон бөгөөд их говийн их бүтээн байгуулалтын сураг чимээг гадаад, дотоодод түгээхэд ач холбогдлоо өгсөн юм.



5. Үндэсний спортын IV наадмын „Тэмээн поло,, болон хурдан тэмээний уралдааныг аймагтаа зохион байгуулж, тэмээ өсгөх уриалга гаргаж, бойжуулсан ботго бүрт 5000 төгрөгийн урамшил олгохоор зарласан. Үндэсний спортын IV наадмыг зохион байгуулсан ажлын амжилтаар тус аймаг улсад шагналт зургадугаар байранд оров.



6. Аймагийн МСҮТ говийн бүсийн уул уурхайн үйлдвэрлэл, түүний дэд бүтцэд ажиллах мэргэжилтэй ажилчин, ажилтныг бэлтгэх ангиудыг шинээр нээж нутгийн залууст мэргэжил олгох, мэргэжлийн зэрэг дэвийг ахиулах боломж бүрдүүлэн Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Мэргэжлийн сургуулиудын холбооноос зарласан уралдаанд “Сургалтын шилдэг орчин бүрдүүлэгч” байгууллагаар шалгарсан



7. Бизнесийн орчны шинэтгэлийн жилд “Дорноговь түншлэл”, “Намрын ногоон өдрүүд”, “Шилмэл мал” зэрэг үзэсгэлэн, худалдаа зохион байгуулж, үйлдвэрлэгчдийг дэмжиж ажилласнаар аж үйлдвэрийн салбарт 2420,1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2690,4 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оныхоос үйлдвэрлэлт 67,6 хувь, борлуулалт 35,7 хувиар нэмэгдүүлсэн амжилт гаргав.



8. Монгол улсын Засгийн газрын “бүртгэлийг төгөлдөршүүлэх” бодлогыг орон нутагт амжилттай хэрэгжүүлж, иргэний шинэчилсэн бүртгэлд иргэдийнхээ 99,7 хувийг хамруулснаар уг ажлын зохион байгуулалтаар тус аймаг улсад тэргүүн байр эзэлсэн.

9. БНСУ-ын Засгийн газартай аймгийн Засаг дарга гэрээ байгуулж, тус улсын буцалтгүй тусламжаар 2.0 сая ам долларын төсөвт өртөгтэй “Дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, сэргээгдэх эрчим хүчний шинэчлэл хийх” төслийг төвийн эрчим хүчний шугамд холбогдоогүй Мандах суманд хэрэгжүүлж, нар, салхины сэргээгдэх эрчим хүчээр сумын төвийн

хэрэглэгчдийг тасралтгүй хангах нөхцлийг бүрдүүлсэн. Мөн уг төслийн хүрээнд гүний ус татаж байгуулсан цөөрмийг түшиглүүлэн 2 хүлэмж байгуулан хүнсний ногоо, 2,0 га газарт мод тарьж цөлжилтийн явцыг саармагжуулахад дэмжлэг үзүүлэв. Ингэснээр Мандах сум бүс нутгийн хэмжээний жишиг сум болов.



10. 2010 оны 11 дүгээр сард Монгол улсын Ерөнхийлөгч Япон улсад айлчлах үед уг айлчлалын албан ёсны бүрэлдэхүүнд аймгийн Засаг дарга П.Ганхуяг оролцож, Дорноговь аймаг Шизуока муж хоорондын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурав.

